



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/84

Ховд

Хяналт шалгалт явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 74 дүгээр зүйлийн 74.1, Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18.1.2, Жижиг дунд үйлдвэрийн газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 1/142 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг дунд үйлдвэрийн газрын "Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай хөнгөлөлттэй зээл аваад эргэн төлөлт болон төслийн хэрэгжилт хангалтгүй байгаа иргэн, аж ахуйн нэгжийн төслүүдэд хяналт, шалгалт явуулах, өр зээлийг барагдуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн дарга

Ч.Эрдэнэбат - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн


Д.Эрдэнэдорж - Хүнс, хөдөө аж ахуйн газрын  
Үйлдвэр, худалдаа үйлчилгээний албаны дарга

Г.Өөдэй - Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга

Нарийн бичгийн  
дарга: Ц.Лувсанлхамо

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн мэргэжилтний үүргийг түр орлон  
гүйцэтгэгч

2. Хөнгөлөлттэй зээл авсан аж ахуйн нэгж, иргэдэд хяналт, шалгалт явуулсан ажлын хэсгийн дүгнэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн Жижиг дунд үйлдвэрийн газарт мэдээ, тайланг хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга /Б.Баярсүх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ

